

## ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Улаанбаатар  
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2021 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа.

### Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд үйл ажиллагаанд холбогдох бодлогын 24, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 74, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 6 баримт бичиг, захиргааны хэм хэмжээний 10 акт болон биелэлт эргэн мэдээлэх шаардлагатай нийт 83 шийдвэрийн 143 арга хэмжээ, зүйл заалтыг хяналтад авч, биелэлт, үр дүнг тооцон, хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, дүгнүүлэхэд харьяа агентлаг, байгууллагуудаас нэгдүгээр байрт шалгарсан.

Монгол Улсын 2 хуулийн 6, Улсын Их Хурлын 2 тогтоолын 9, Улсын Их Хурлын Байнгын хорооны 6 тогтоолын 18, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 10, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 6 зөвлөмжийн 17, Засгийн газрын 40 тогтоолын 61, Ерөнхий сайдын 1 захирамжийн 1, Засгийн газрын хуралдааны 21 тэмдэглэлийн 33, Засгийн газрын 3 албан даалгаврын 20, нийт 83 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 175 арга хэмжээ, зүйл заалтыг хэрэгжилтийг энэ оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/509 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах”, “Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах” гэсэн зорилтыг дэвшүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/95 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194, 209, 226 дугаар, 2021 оны 27, 45, 78, 91, 105, 115, 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 12, 2021 оны 01, 02, 04 дүгээр тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын бие бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 3 удаа, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2 удаа тус тус шилжүүлэн ажиллуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2021 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, нийт 6 удаа хуралдан, хуралдаанаас гарсан шийдвэр, мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг холбогдох анги, байгууллагад тухай бүр хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нийт 37 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж өгснийг анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг тухай бүр тооцон ажиллаж байна.

Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой энэ онд тохиохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, дэд ажлын хэсгүүдийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн тушаалаар байгуулж, ойг

тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг 13 бүлэг, 95 ажил, арга хэмжээтэй төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**1.1.Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2020 оны А/02, А/03 А/64 дүгээр тушаалаар “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г тус тус баталж, энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 2980 удаагийн 3334 цагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 414418, мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн 1987 төрлийн ажил, арга хэмжээг мэдээлэл, технологийн өргөн боломжийг ашиглан зайн болон цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 378234 алба хаагчийг хамруулан үр дүнг тооцсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмуудыг алба хаагчдад судлуулах, зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 155 удаагийн сургалтад 18110, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 43 удаагийн сургалтад 20527, Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр 70 удаагийн сургалтад 35324, Дотоодын цэргийн үйл ажиллагаа, улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 43 удаагийн сургалтад 44311, мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын чиглэлээр 52 удаагийн сургалтад 6908 алба хаагч тус тус хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн төр, захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран 163 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 4678 алба хаагч, 35678 иргэнийг хамруулсан.

Алба хаагчдын сургалтад зориулж 472 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 538 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 3265 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 16.6 сая төгрөг зарцуулсан.

Мөн Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд алба хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 82 удаагийн зайн болон цахим сургалтад давхардсан тоогоор 7195 алба хаагчийг хамруулан, сургалтын багц кредит цаг хангуулан, гэрчилгээ олгож, иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтын хүрээнд олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх 2 удаагийн сургалтад 48, иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны 14 удаагийн сургалтад 531 иргэнийг хамруулж, гэрчилгээ олгосон.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын их дээд сургуулиудтай хамтран ажиллаж, цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ хөтөлбөрийн сургалтад 138, магистрын хөтөлбөрийн сургалтад 45, докторын хөтөлбөрийн сургалтад 13, Удирдлагын сургуульд 20, ОХУ, БНХАУ, БНТУ, БНСУ, БНУУ зэрэг 5 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 91, нийт 307 алба хаагчийг суралцуулж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, удирдах ажилтны мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор удирдах ажилтны 2021 оны сургалт, зөвлөгөөнийг энэ оны 02 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулж, анги, байгууллагын 54 байршлаас 514 удирдах ажилтныг амжилттай хамруулсан.

Мөн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч бүрэлдэхүүний 2021 оны цахим сургалт, зөвлөгөөнийг энэ оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу дэлхий нийтэд тархаад буй коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Улсын онцгой комисс, эрүүл мэндийн байгууллагаас өгч буй зөвлөмжийг баримтлан мэдээллийн технологийн өргөн боломжийг ашиглан анх удаа цахимаар 72 байршлаас 2688 алба хаагчийг хамруулсан.

Цагдаагийн байгууллагад шинээр томилогдсон хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах алба хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд алба

хаагчдыг чадавхжуулах нь” сэдэвт сургалтыг цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Б/199 дүгээр тушаалын дагуу 02 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулж, алба нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 178 алба хаагч, мөрдөгчийг амжилттай хамруулсан.

Коронавирусийн халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, хүний нөөцийн хэрэгцээ, шаардлагын хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтран “Цагдаа”, “Цагдаа-жолооч”, “Дотоодын цэргийн харуулчин” мэргэжил олгох цахим сургалтыг 33 анги, байгууллагыг түшиглэн 2 удаа амжилттай зохион байгуулж, 646 иргэнийг суралцуулж, албан тушаалд томилсон.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд дэвшүүлсэн “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчил, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, бууруулах, алба хаагч, ажилтны эрх хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор “Харилцаа, Хандлага” аяныг зохион байгуулж, нийт 7800 алба хаагчийг багтаасан хаалттай группэд 225 төрлийн мэдээ, мэдээлэл, 12 шууд нэвтрүүлэг хийж, 15 видео мэдээлэл оруулж, 15-аас дээш жил ажиллах хугацаандаа сахилгын арга хэмжээ авагдаагүй 35 алба хаагчийг сурталчилж, аяны үйл ажиллагааг идэвхжүүлсэн.

**1.2.Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:** Гадаад орны цагдаагийн байгууллага, олон улсын чиг үүрэг бүхий бусад байгууллагатай харилцан хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан “Энхийг сахиулагч өдөрлөг”-ийн арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг дэмжих ажиллагаанд бие даасан цагдаагийн ажилтнаар үүрэг гүйцэтгэсэн 19 алба хаагч оролцсон бөгөөд Батлан хамгаалахын сайдын 2021 оны Б/19 дүгээр тушаалаар “Африкт энхийн төлөө” дурсгалын медалиар 9 алба хаагчийг шагнаж, урамшуулсан.

Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний дагуу “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гадаад хамтын ажиллагаа, цаашдын чиг хандлага” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (СICA)-ын үйл ажиллагааны хүрээнд Бүгд Найрамдах Турк Улсын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын академиас энэ оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 04-ний хооронд зохион байгуулагдсан “Гэмт хэргийн талаарх мэдээллийн дүн шинжилгээ”, “ Зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаа ба арга зүй” сэдэвт цахим сургалтад 4, Монгол Улсын Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яамтай хамтран энэ оны 04 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын танилцуулга сургалтад 3 алба хаагчийг тус тус хамруулсан.

**1.3.Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 55 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 87 удаа оролцсон.

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах Зөвлөл, анги, байгууллагын Дэд зөвлөлийн хоёрдугаар хуралдааныг энэ оны 02 дугаар сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд хуралдаанд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 57 нэгжийн дарга, захирагч нар оролцож, 2020 онд тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах

чиглэлээр анги, байгууллагуудын ирүүлсэн тайлан мэдээнд хяналт-шинжилгээ хийсэн талаар мэдээллийг танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.

“Алба хаагч ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” цахим группээр дамжуулан алба хаагч, ажилтнаас ирүүлсэн мэдээлэл, санал хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, шалтгаан нөхцөлийг арилгах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газарт хүргүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтнаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 101 үйлдэлд 102 алба хаагч, зөрчлийн шинжтэй 4 үйлдэлд 4 алба хаагч хохирч, гэмт хэргийн шинжтэй 1 үйлдэлд 1 алба хаагч холбогдон шалгагдаж байна.

Албан үүргээ гүйцэтгэх явцдаа халдлагад өртсөний улмаас 12 алба хаагчийн биед гэмтэл учирснаас 10 тохиолдолд үйлдвэрлэлийн ослын шалтгаан нөхцөлийг судлан бүртгэж, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулахаар хүргүүлж, 2 үйлдэлд ослын шалтгаан нөхцөлийг судалж бүртгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай, Шүүх шинжилгээний тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон дагалдан гарах зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал боловсруулан ажилласан.

Мөн хуулийн 26 төсөлд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас санал авч нэгтгэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яам болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Гадаад улстай байгуулах хэлэлцээрийн 4, хамтран ажиллах санамж бичгийн 7, төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах гэрээний 18, ажил гүйцэтгэх гэрээний 20, даатгалын гэрээний 3, түрээсийн гэрээний 2 төслийг тус тус хянаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын батлан гаргасан 27 хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргүүлж, мэдээллээр хангасан.

**1.4.Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газраас 196.230 дагагч бүхий албан ёсны пэйж хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төв болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны пэйж хуудаснаас мэдээ, мэдээллийг эх сурвалжийн хамт хуулбарлан авч, иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын пэйж хуудсанд авлига, ашиг сонирхлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утга агуулга бүхий постер 13, мэдээ, мэдээлэл 7, видео шторк 8, нийт 28 мэдээлэл байршуулсан нь 896.241 хүнд хүрч, 285 удаа бусадтай хуваалцсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайт болон байгууллагын цахим хуудсанд, “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх /давхардсан тоогоор/ нийт 33 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу тус тус байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын Авлигын эсрэг эрх зүйн орчин, төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаанд мониторинг хийсэн зөвлөмжийн цагдаагийн байгууллагад хамаарах 6

зорилт, 25 ажил арга, хэмжээний хэрэгжилтийг энэ оны эхний 5 сарын байдлаар 88.8 хувиар үнэлж, энэ оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 3/216 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газраас 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/696 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 6 зорилт, 51 заалтын хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг энэ оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

### **Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар**

**2.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах” гэмт хэрэгт өртөж хохирсон охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дээрх гэмт хэргийн хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор “Мөрөөдлийн шүхэр” аян, арга хэмжээг энэ оны 03 дугаар сарын 05-28-ны өдрийг хүртэл 23 хоногийн хугацаанд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-тай хамтран зохион байгуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төв, Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийн 2020 оны судалгааны тайланд үндэслэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд нийт 13 төрлийн 39.000 ширхэг тараах материалыг хэвлүүлэн байршуулж, цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Судалгаа, хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн объектын судалгаанд 187 аж ахуйн нэгжийг, субъектийн судалгаанд 354 биеэ үнэлэгч, зохион байгуулагч, энэ төрлийн хэрэгт холбогдож болзошгүй этгээдийн талаарх мэдээллийг нэмж оруулсан.

Гэмт хэргийн хор уршиг, урьдчилан сэргийлэх арга зам, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх болон цагдаагийн байгууллагаас гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг таниулах зорилгоор 15 телевиз, өдөр тутмын 3 сонин, 25 сайт, 12 фм радиогоор тус тус телевизийн 3 хэлэлцүүлэг, 2 зорилтот нэвтрүүлэг, 15 мэдээ сурвалжилга, 18 ярилцлага өгч, 15 мэдээ, сурвалжилга бэлтгэн иргэд, олон нийтэд тогтмол түгээсэн.

Цагдаагийн байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ирээдүйгээ-хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг энэ оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, мэдээллийг нийт 12 телевиз, 24 сайт, 8 радиогоор иргэд, олон нийтэд хүргэсэн.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан танхимын сургалтаас татгалзаж дүүргийн шүүх, прокурор, удирдах ажилтнуудтай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн цахим зөвлөгөөн, 22 удаагийн уулзалт хэлэлцүүлэгт дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдийн эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн болон архины хамааралтай 4480 иргэн, түүнчлэн 36 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 2085 иргэн хамрагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 110, орчин цагийн Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг угтаж байгууллага, хамт олноо сурталчлах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл “Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэгтэй уран бүтээлч алба хаагчдыг оролцуулсан “Эх орны тангарагтай андууд-2” онлайн тоглолтыг энэ оны 03 дугаар сарын 18-ны өдөр Check.mn сайттай хамтран зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагаас энэ оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд нийт 2, тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр 254 арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан.

**2.2.Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:** Тус алба хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа сэрдэгдсэн болон оргодол этгээдүүдийг олж тогтоох зорилгоор “Шийдвэрлэлт”, “Шүүхээс даалгасан бусад хүн 2021”, “Тоглоом”, “Шоо”, “Яргуй”, “Урамшуулал”, “Сүлжээ” зэрэг нийт 7 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улс, нийслэлийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцсон.

Албаны хэмжээнд 2072 холбогдогчтой, 9.9 тэрбум төгрөгийн хохиролтой, 7392 хэрэг бүртгэлтийн хэргийг илрүүлж, мөрдөн байцаалтад шилжүүлсэн бөгөөд нийт хэргийн 1294 буюу 17.5 хувийг хүнд, 6098 буюу 82.5 хувийг хөнгөн ангиллын хэрэг эзэлж байна.

Илрүүлсэн хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2191 нэгжээр буюу 29.6 хувиар, гэмт хэргийн гаралт эхний хагас жилийн байдлаар 10515 нэгжээр буюу 37,6 хувиар тус тус өсч, илрүүлэлт 33.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрэн сурвалжлах “ASAP” санд хүн, мал амьтан, эд зүйлийн 10547 мэдээллийг бүртгэн зарлаж мэдээлснээс 7191 хүн, мал амьтан, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон. Эрэн сурвалжлах ажлын илрүүлэлт 68.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 7.9 хувиар өссөн байна.

Эрэн сурвалжлах “ASAP” санд алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас шүүхээс даалгасан бусад хүний төлөвт нийт 2251 хүний мэдээллийг бүртгэж зарласнаас 1386 хүнийг олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоосон нь илрүүлэлт 61.5 хувьтай байна.

“Шүүхээс даалгасан бусад хүн 2021” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагын “ASAP” санд эрэн сурвалжлагдаж байсан этгээдүүдийн 26.0 хувь буюу 935 хүнийг олж тогтоосон нь илрүүлэлтийн хувь 20.1 хувиар өссөн.

Эрүүгийн цагдаагийн албаны харьяа нэгжүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 16857 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 15937 буюу 94.5 хувийг шийдвэрлэсэн бөгөөд улсын хэмжээнд нийт хэрэг бүртгэлтийн 22348 хэрэгт ажиллагаа явуулснаас 1077 хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татах саналтай мөрдөн байцаалтад, 5929 хэргийг хаах, 340 хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, 46 хэргийг нэгтгэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, нийт хэргийн 7392 буюу 33.0 хувийг шийдвэрлэж, одоо ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 14956 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас 65.0 хувь нь нийслэлд, 5361 буюу 35.0 хувь нь орон нутагт шалгагдаж байна.

Улсын ерөнхий прокурорын туслах прокурорын тогтоол, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтран баталсан тушаалаар хэрэг бүртгэлтийн 5, мөрдөн байцаалтын 4, нийт 10 хэрэгт 9 ажлын хэсэг байгуулагдаж, давхардсан тоогоор 6, мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор байгуулагдсан 4 ажлын хэсэгт давхардсан тоогоор 5, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр байгуулагдсан хамтарсан ажлын хэсэгт 4 алба хаагч томилогдон мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Нууц, далд аргаар үйлдэгдсэн эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээллийг шалгаж баримтжуулах зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа төв, орон нутгийн 16 хорих анги, Сургалт хүмүүжлийн тусгай нэгж, Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт чиглэл хариуцсан алба хаагчид ажиллаж, үр дүнг тухай бүр тооцон ажиллаж байна.

**2.3.Мөрдөн байцаах албаны чиглэлээр:** Мөрдөн байцаах албаны харьяа нэгжүүд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэргийн шинжтэй 17167 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5423 нэгжээр буюу 31.5 хувиар өссөн бөгөөд нийт гомдол, мэдээллийн 6578 буюу 38.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 9185

буюу 53.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 182 буюу 1.0 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, нийт шалгасан гомдол, мэдээллийн 15945 буюу 92.8 хувийг шийдвэрлэсэн.

Мөн хэрэг бүртгэлтийн 17132 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үеэс 83 нэгжээр буюу 0.4 хувиар өссөн бөгөөд нийт шалгасан хэрэг бүртгэлтийн хэргийн 3029 буюу 17.6 хувийг хааж, 7385 хэрэг буюу 43.1 хувийг шүүхэд шилжүүлж, 936 хэрэг буюу 5.4 хувийг хэрэгсэхгүй болгож, 1713 хэрэг буюу 9.9 хувийг нэгтгэн, хуулийн анхны хугацаанд 60.0 хувийг шийдвэрлэсэн байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт өмнөх оны мөн үеийнхээс 1.6 хувиар өсч, шалгасан хэргийн 451 буюу 2.6 хувь нь прокуророос, 152 буюу 0.9 хувь нь шүүхээс буцсаныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал прокуророос буцсан хэрэг 43.5 хувь, шүүхээс буцсан хэрэг 25.8 хувиар тус тус буурсан.

Гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 506815.7 сая төгрөгийн хохирлын 253559.8 сая төгрөг буюу 50.3 хувийг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, 331828.4 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилсэн.

Мөрдөн байцаах албаны хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 47.9 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.4 хувиар өссөн байна.

**2.4.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Улсын хэмжээнд эхний хагас жилд 35607 зөрчил илрүүлж, 37025 иргэн, албан тушаалтан, 52 хуулийн этгээдийг 1.070.487.100 төгрөгөөр торгож, 24551 хүний эрүүлжүүлж, 509 хүнийг шүүхээр баривчлуулж, 10238 хүнийг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 57.956 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.464 буюу 14.0 хувиар буурсан бөгөөд 5.677 гэмт хэрэг бүртгэгдсэнээс гудамж талбайд 840 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын онцгой комиссын хэрэгжилтийг хангах, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, хорио цээрийн дэглэм сахиулах үүргийг хэрэгжүүлж явган эргүүлд 297, шинжилгээний цэгт 18, вакцины хамгаалалтад 25, хяналтын цэгт 22, замын хяналтад 59, угтах үйлчилгээнд 7, камерын хяналт 7, хамтарсан шалгалтад 2, нийт 437 олон нийтийн цагдаа ажиллаж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа зөрчлийн шинжтэй 305 зөрчлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч 4.524.500 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

**Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар:** Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт 5 удаа цахимаар мэдээлэл хийж, үүрэг, ажлын чиглэл өгч, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штаб, төв, орон нутаг дахь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор Тэргүүн дэд, Дэд даргаар ахлуулсан зөвлөлийн гишүүдийг хуваарьт оруулан 24 цагаар үүрэг гүйцэтгүүлсэн.

Нийслэл хотод орох, гарах хөдөлгөөнд хяналт тавих 7 постоос Эмээлт, Гүнтийн давааны 2 постод 3, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг, Амар, Наранбулаг, Парк, Дреам, Корпорейт, Кентавор, Тоёоко-Инн, Туушин зочид буудлууд, Жаргалант сургалтын нэгдсэн төв зэрэг тусгаарлан ажиглах байрууд, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 48, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 63, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг дэх гудамж, талбайн телехяналтын камерын дүрсийг Шуурхай удирдлагын штабт холбож, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.

Нийслэлийн онцгой комиссоос Улаанбаатар хотын хэмжээнд явганаар болон тээврийн хэрэгслээр зорчих иргэдэд “www.smartcar.mn” цахим хуудсаар дамжуулан “QR Code” бүхий зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дагуу цагдаа, дотоодын цэргийн алба

хаагчид бэлэн бус торгуулийн “еПатрол” программ хангамжаар шалгах боломжийг бүрдүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын талаар худал мэдээ, мэдээлэл тараасан, бусдыг уриалсан зэрэг зөрчлийг шалган шийдвэрлэх, халдвартай иргэдийг нийслэл, орон нутгаас Халдварт өвчин судлалын үндэсний төв, Цэргийн төв эмнэлэг рүү татан авах ажиллагаа, тусгаарлан ажиглах байруудын хамгаалалт, хүнсний зах, худалдааны төвүүдэд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, замын хөдөлгөөн зохицуулалт, хяналтын постуудад нийт 52 анги, байгууллагын 9967 алба хаагч, 24 цаг болон 2 ээлжээр тасралтгүй, нэмэгдлээр Дотоод хэргийн их сургуулийн 2100, Нийслэлийн онцгой байдлын газраас 58, олон нийтийн 119 цагдаа тус тус үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргаас өгсөн чиглэлийн дагуу энэ оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед хорио цээрийн дэглэм сахиулах чиглэлээр холбогдох төлөвлөгөө, зураглал, хуваарийн дагуу 3695 эргүүл, хяналтын цэгт нэмэгдлээр яам, агентлаг, төрийн захиргааны байгууллагын 6231, ажилтан, албан хаагчийг 3 ээлжээр хуваарилан томилгоожуулж, үүрэг гүйцэтгүүлсэн.

Баталгаат болон баталгаат бус замаар хорио цээрийн дэглэм зөрчин зорчиж байгаа үйлдлийг таслан зогсоох, хяналт шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас хойш нийслэл хот руу нэвтрэх чиглэлд 178448 тээврийн хэрэгсэл, 373837 иргэн, гарах чиглэлд 220941 тээврийн хэрэгсэл, 508596 иргэн, нийт давхардсан тоогоор 399389 тээврийн хэрэгсэл, 882433 иргэнийг тус тус шалган нэвтрүүлж, хамгаалалт, зохицуулалтад хоногт 105 алба хаагч, 11 автомашинтай үүрэг гүйцэтгэж байна.

Буянт-Ухаа агаарын хилийн боомтоор гадаадын 96 улсаас тусгай үүргийн 173 удаагийн нислэгээр Монгол Улсын 28018 иргэн, гадаад 48 улсын 2229 иргэн, ОХУ-ын хилийн боомтоор 58 удаагийн татан авалтаар Монгол Улсын 2493 иргэн, гадаадын ажиллах хүч 9 аж ахуйн нэгж, цагаач, гэр бүлийн хамаарал бүхий 208 иргэн, БНХАУ-аас хилийн боомтоор 11 удаагийн татан авалтаар Монгол Улсын 4301 иргэн, гадаадын ажиллах хүч 130 аж ахуйн нэгж, цагаач, гэр бүлийн хамаарал бүхий 2474 татан авч, нийт улсын хэмжээнд Монгол Улсын 34812 иргэн, гадаад улсын 7197 иргэнийг татан авч, тусгаарлах үеийн хамгаалалтад давхардсан тоогоор цагдаагийн байгууллагаас 15.652 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, аливаа эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэлийн хэмжээнд 610 орон сууцны 1484 орц, хонгил, 51 барилга байгууламж, 6 хүнсний зах, худалдааны төв, 46 дулааны худаг, хоёрдогч түүхий эд авах цэгт үзлэг шалгалт хийж, гэр оронгүй, тэнэмэл байдлаар амьдардаг 107 хүнийг олж тогтоон, Нийгмийн хамгааллын тусгай төвд 77, Шинэ амьдрал ялагч, Өлзийт асар, Тэрэм-Уул, Титэм констракшн зэрэг 4 төрийн бус байгууллагад 30 хүнийг хүлээлгэн өгч, коронавируст халдварын PCR шинжилгээнд хамруулсан.

**Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:** Улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 57.956 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.464 буюу 14.0 хувиар буурсан бөгөөд гэмт хэргийн шинжтэй 12.480, зөрчлийн шинжтэй 41.384 гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд 327.298 зөрчил бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 218.564 буюу 40.0 хувиар буурч, бүртгэгдсэн зөрчлийн 229.782 буюу 70.2 хувь нь нийслэлд, 97.516 буюу 29.8 хувь нь орон нутагт үйлдэгдсэн байна.

Нийт 325.751 зөрчил шийдвэрлэснээс 306.182 иргэн, 10.031 хуулийн этгээдийг нийт 12.3 тэрбум төгрөгөөр торгож, 5731 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 3.807 хүнд шүүхээр баривчлах шийтгэл оногдуулсан бөгөөд нийт зөрчлийн 16.505 согтуугаар, 68 бүлэглэн, 1.753 эмэгтэй хүн оролцсон, 126 хүүхэд оролцсон, 2.777 гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.



Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой Прокурорын байгууллагаас ирүүлсэн шаардлагын судалгааг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудаас авч нэгтгэн, Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавих хэлтэстэй тулгалт хийж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуультай холбогдуулан цагдаагийн байгууллагад хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн нийт 92 гомдол, мэдээлэл хүлээн авснаас хүний улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 79 гомдол, мэдээлэл, бусад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 13 гомдол, мэдээллийг хүлээн авч, 71 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн болон зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 8 гомдол, мэдээллийг харьяаллын дагуу бусад газарт шилжүүлж, 8 хүнийг 40.8 сая торгож шийдвэрлэсэн.

**2.5.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:** Тус алба иргэд, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 24352 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8281 нь зам тээврийн осол, хэргийн, 130 нь төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт, 10 нь нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэл байна.

Дээрх дуудлага, мэдээллээс цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 314, зөрчлийн шинжтэй осол 7941, төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 12, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 4 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 80 хүн нас барж, 268 хүн гэмтэж, зам тээврийн ослын улмаас иргэд, байгууллагад 8.0 тэрбум 330.5 сая төгрөгийн хохирол учирсан.

Мөн нийт 642587 захиргааны зөрчил илрүүлснээс замын цагдаагийн чиглэлээр 628991, төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 5179, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 8417 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн.

Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дуудлага, мэдээлэл 3337 нэгжээр буюу 12.1, нас барсан хүн 38 нэгжээр буюу 32.2, гэмтсэн хүн 70 нэгжээр буюу 20.7, гэмт хэрэг 128 нэгжээр буюу 28.6, иргэд, байгууллагад учирсан хохирол 1.1 тэрбум төгрөг буюу 11.9, бүртгэгдсэн зам тээврийн осол 2016 нэгжээр буюу 19.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гудамж замын хөдөлгөөнд оролцсон 14609, замын хөдөлгөөнд оролцох шаардлага хангаагүй журамлагдсан 11100 зөрчил, бусад 1595 хэрэг, зөрчил, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд эрэн сурвалжлагдаж байгаа 594 хүн, эд зүйлийг олж тогтоон илрүүлж, санд бүртгэн холбогдох албадад харьяаллын дагуу шилжүүлсэн.

Нийслэл хотын гудамж замд байрлах замын хөдөлгөөний хяналтын төхөөрөмжөөр нийт 161020 зөрчил илрүүлснээс хурдны зөрчил 58295, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээний зөрчил 71211, түр зогсох журам зөрчсөн зөрчил 29748, үзлэг оношилгоонд ороогүй 511 зөрчлийг баталгаажуулан, арга хэмжээ тооцож тээврийн хэрэгслийн эзэмшигчийн хаягаар хүргүүлсэн.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 478 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтай 41, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 100, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай 261, бусад газар шилжүүлсэн 8, нийт 410 гомдол мэдээллийг шийдвэрлэж одоо 68 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ба нийт хүлээн авсан гомдол мэдээллийн 85.7 хувийг шийдвэрлэсэн байна.

Урьд оны үлдэгдэл 28 хэрэг бүртгэлтийн хэрэг дээр шинээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 100, хэрэг бүртгэлтийн хэрэг хааснаас сэргээсэн 5, шилжиж ирсэн 14, тусгаарласнаас ирсэн 1, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсанаас сэргээсэн 8, нийт 156 хэрэгт бүртгэлтийн хэрэгт ажиллагаа явуулснаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар

татсан 92, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай 37, бусад газар шилжүүлсэн 4, нийт 133 хэргийг буюу 85.2 хувийг шалгаж шийдвэрлэсэн.

Нийслэлийн хэмжээнд явган хүний замыг нарийсгаж, явган зорчигч чөлөөтэй зорчих боломжгүй болгосон, тээврийн хэрэгслийн жолоочийн үзэгдэх орчинг хязгаарлаж зам тээврийн осол, хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлсэн хашаа, объектын судалгааг гаргаж, зөрчлийг арилгуулах талаар Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт инженерчлэлийн газруудад албан бичгээр мэдээлэл хүргүүлж, уг ажлын хүрээнд “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар”-аас Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлуулсан өнгө үзэмжгүй, явган хүний хөдөлгөөнд саад учруулж буй 48 ширхэг хаяг, мэдээллийн байгууламжуудыг албадан буулгах ажил хийгдэж, үзэгдэх орчныг сайжруулж, явган зорчигч аюул, саадгүй зорчих боломжийг бүрдүүлсэн.

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суух элчин сайд нар Монгол Улсын Ерөнхийлөгчид итгэмжит жуух бичиг өргөн барих ёслолын ажиллагаа, ОХУ-ын “Газфром” НХН-ийн удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал, Монгол цэргийн бахархлын өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой болон Төрийн туг цэнгүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны үеийн хэв журмын хамгаалалт зохицуулалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээ, сэрэмжлүүлэг, ноцтой зам тээврийн осол гэмтэл, замын байгууламжийн талаарх мэдээ мэдээлэл зэргийг бэлтгэн, 58 телевизэд давхардсан тоогоор 30 төрлийн мэдээ мэдээллийг 116 удаа, фм радиод 12 төрлийн мэдээллийг 108, албаны болон бусад цахим 51 сайтад 16 төрлийн мэдээллийг 180 удаа, 3 төрлийн сонинд 5 төрлийн мэдээллийг тус тус өгч, иргэд, олон нийтэд түгээсэн.

Орон нутгийн авто замд үйлдэгддэг зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, мэдлэг мэдээлэл олгох, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Оюу толгой” ХХК-тай хамтран улсын хэмжээнд энэ оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд “Ирээдүйгээ хамгаалъя” уриатай “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2021” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна.

**2.6.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын гомдол, мэдээллийн болон гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санд 1.098.814 нэгж мэдээлэл бүртгэгдсэн.

Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас сүлжээгээр ирүүлсэн 264 албан бичгийн дагуу 5228 хүн, 53 хуулийн этгээд, “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалах хуудас”-аар 1732 хүнийг тус тус шалган хариу өгч, иргэдийн хүсэлтээр 3719 ширхэг тодорхойлолт олгон, ялтны хувийн хэргээс хуулбар авах тухай 650 албан бичгээр 673 хүнд холбогдох 1002 хувийн хэргээс 12320 хуудас материалыг хуулбарлаж өгсөн.

**Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:** Энэ оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллага нийт 115.311 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсаны 29.230 буюу 25.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 86.081 буюу 74.6 хувь нь зөрчлийн шинжтэй байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 9565 буюу 32.7 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 16792 буюу 57.4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 355 буюу 1.2 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлсэн.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 4988 буюу 17.1 хувийг 5 хоногт, 21152 буюу 72.4 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн бөгөөд улсын хэмжээнд 10595 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 6715 буюу 63.4 хувь нь нийслэлд, 3868 буюу 36.5 хувь нь орон нутагт, 12 буюу 0.1 хувь нь бусад газар бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 3348 буюу 24.0, нийслэлийн хэмжээнд 2349 буюу 25.9, орон нутагт 998 буюу 20.5, бусад газарт 1 буюу 7.7 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд нийт 10595 гэмт хэрэг бүртгэгдсэний 6715 буюу 63.4 хувь нь нийслэлд, 3868 буюу 36.5 хувь нь орон нутагт, 12 буюу 0.1 хувь нь бусад газар /хилийн чанадад/ бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 3348 буюу 24.0, нийслэлийн хэмжээнд 2349 буюу 25.9, орон нутагт 998 буюу 20.5, бусад газар /хилийн чанадад/-т 1 буюу 7.7 хувиар тус тус буурсан байна.

Хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 60.4, Дээрэмдэх гэмт хэрэг 53.7, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5.5, Хүчиндэх гэмт хэрэг 6.5 хувиар тус тус буурч, Залилах гэмт хэрэг 5.6, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 22.4, Цахим гэмт хэрэг 22.5 хувиар тус тус, Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2.5 дахин өссөн.

Улсын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 44.2, нийслэлд 43.4, орон нутагт 46.4 хувь байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 0.2, нийслэл хотод 2.0 нэгжээр тус тус өсч, орон нутагт 3.1 нэгжээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 21 хуулийн этгээд, 10259 иргэн хохирсноос 280 хүн нас барж, 3666 хүн гэмтсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 101 буюу 26.5, гэмтсэн хүн 338 буюу 8.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр:** Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн 226.031 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас зөрчлийн 163.801, гэмт хэргийн 9520, сураггүй алга болсон хүн 1448, олдсон хүүхэд /хүн/ 818, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 21.321, зам тээврийн осол, хэргийн 29.123, үүнээс гадаадын иргэнтэй холбоотой 97, архидан согтуурсантай холбоотой 65.554, цагдаагийн алба хаагчтай холбоотой 359, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 79 мэдээ, мэдээлэл бүртгэгджээ.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах, холбогдох байгууллагад холбон зуучлах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдийн тусламжийн 108 дугаараас цагдаагийн байгууллагын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 102 тусгай дугаарт ирүүлсэн 1297 дуудлагыг хүлээн авч, хамтран ажилласан.

Орон нутаг болон дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсээс зарлуулахаар ирүүлсэн сураггүй алга болсон болон олдсон хүн /хүүхэд/, хулгайд алдагдсан тээврийн хэрэгсэл, эд зүйлс, мал зэрэг нийт 124 мэдээллийг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээгээр зарлан мэдээлсэн.

Шуурхай удирдлагын хэлтсүүд хооронд шилжүүлсэн нийт 3596 дуудлага, 102 тусгай дугаарын утсанд бүртгэгдсэн хулгайн 1274, хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн 20.261 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 1177, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 8977, сураггүй алга болсон гэж мэдээлэл өгсөн 1267, нийт 11421 иргэнтэй холбогдож, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.

**2.7.Архивын үйл ажиллагааны чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын дэргэдэх Нууц баримт нягтлан шалгах арга зүйн комиссын энэ оны 01 дүгээр хурлыг энэ оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, нийт 22 байгууллагын нууцын зэрэглэлд хамаарах баримтын 41 жагсаалт, 1165 хадгаламжийн нэгжийг хянан хэлэлцсэнээс 17 байгууллагын жагсаалтыг баталгаажуулж, 5 байгууллагын баримтын бүрдэл дутуу үндэслэлээр буцааж дахин бүрдүүлэлт хийлгэхээр шийдвэрлэсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад 2018 оны нууцын зэрэглэлтэй баримтаар нөхөн бүрдүүлэлт хийх, баримт шалгуулж арга зүйн зөвлөгөө өгөх хуваарийг хурлаар хэлэлцүүлж, Төв архивын даргаар баталгаажуулан анги, байгууллагуудад энэ оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 24/680 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Хөмрөг үүсгэгч 30 байгууллагын байнга 31, түр 30, санхүүгийн 70 жил хадгалах 9, “Б” тушаалын 70 жил хадгалах 18, боловсон хүчний хувийн хэргийн бүртгэл 9, устгах хэргийн акт 11, нийт 97 бүртгэл, 11 устгах хэргийн актыг хянаж, 7 байгууллагад зөвлөмж бичиж буцаан, алдааг засуулж, Төв архивын дэргэдэх БНШАЗК-ын 01 дүгээр хурлаар 2020 онд хянасан 25 байгууллагын 134 бүртгэл, 34 устгах хэргийн актыг баталгаажуулан үндсэн байгууллагад нь албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэд хүлээн авах байраар 527, албан бичгээр 103, өргөдлөөр 10 захиалга авч, 640 архивын лавлагаа, тодорхойлолт гарган олгосон бөгөөд байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 43 хөмрөгийн 45 дансны 267 хадгаламжийн нэгжийн 54598 хуудас баримтаас шүүлт хийж, 843 хуудас баримтыг хуулбарлан баталгаажуулж олгосон.

Цаасан суурьтай баримтыг лавлагаа, мэдээлэл, уншлагын танхим, судалгаа, эрдэм шинжилгээ, нягтлан шалгалтад зориулж 86 хөмрөгийн 90 данс бүртгэлийн 800 хадгаламжийн нэгжийн 164788 хуудас баримтыг бүртгэлийн дагуу олгож, ашиглуулсан.

Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгийн эмхэтгэл” /1911-2021 он/, “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүх” /1911-2021 он/ номуудыг эмхэтгэх ажлын хэсгийн эрдэмтэн судлаачид ном эмхэтгэх ажлыг дуусч, редакцын ажил хийгдэж, “Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүхэн баримт бичгийн эмхэтгэл” /1911-2021 он/ номыг эх бэлтгэлд бүрэн шилжүүлсэн.

**2.8.Хэвлэл, мэдээллийн чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын албан ёсны [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) сайтад байгууллага, алба хаагч, аян арга хэмжээтэй холбоотой 38 ярилцлага, цаг үе, үйл явдлын 52, бусад 13, нийт 103 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулсан нь давхардсан тоогоор 3.114.784 хүний хандалт авсан.

Хэвлэл, мэдээллийн төвийн фэйсбүүк цахим хуудаст цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 507 онцлог үйл явдал, аян арга хэмжээ, ярилцлага, мэдээ мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд түгээсэн нь давхардсан тоогоор 13.741.148 хүнд хүрснээс 625.314 хүнд таалагдаж, 919.501 хүн хуваалцсан байна.

“Монгол төрийн цагдаа” эмхэтгэлийн 2020 оны IV улирлын дугаар, энэ оны I улирлын дугаарыг “Адмон” ХХК-ний хэвлэлтээс тус бүр 2000 буюу нийт 4000 ширхгийг хүлээн авч Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хуваарийн дагуу тараан олгож, энэ оны II улирлын сэтгүүлийг бэлтгэж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажилласан алба хаагчдыг алдаршуулах, сурталчлах ажлын хүрээнд “Бидний нэг” нэвтрүүлгийн 4 удаагийн дугаар, “Токио 2020” зуны олимпын ХХII наадамд оролцож буй 4 алба хаагчийн талаарх 2 ярилцлага, 2 хөрөг, 3 постер, нийт 7 мэдээ, мэдээлэл, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Та гэртээ хамгийн аюулгүй” 6 удаагийн зурагт постер, “Гэртээ байцаая” сэдэвт 24 удаагийн видео уриалга, шторкыг тус тус бэлтгэн, иргэд, олон нийтэд түгээсэн.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр давхардсан тоогоор 457 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, тодруулга мэдээллийг өгсөн.

Иргэд, олон нийтэд олон талт мэдээ, сэрэмжлүүлэг, мэдээллийг хүргэх зорилгоор “Клабхаус” апплейкшнээр дамжуулан “Хөл хорио ба гэмт хэрэг” цахим ярилцлагыг 2 удаа, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан эерэг контент түгээх зорилгоор “Гэрлэх санал тавьсан өдрөө гэнэтхэн орхиод явсан хань минь” нэртэй 2 удаагийн захидал, “Дурсамж тэмдэглэл” “С.Нандин-Эрдэнэ охиноос ирүүлсэн захидал” зорилтот нийтлэлийг тус тус бэлтгэн түгээсэн.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээллийг түгээх ажлын хүрээнд “Амрыг эрье” 15, 20, минутын нэвтрүүлгийн нийт 24 удаагийн дугаар бэлтгэж, 12 телевизээр 48 удаагийн давталттайгаар дамжуулан иргэд, олон нийтэд түгээсэн.

“Police podcast” хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэс, Хуулийн хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Аюулгүй байдлын хэлтэс, Дотоодын цэргийн штаб, Санхүү, аж ахуйн алба, Тээврийн цагдаагийн алба, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах

алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газартай хамтран 11 удаагийн ярилцлага бэлтгэн түгээсэн байна.

**2.9.Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр:** Монгол Улсад Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дунд 15, ахмад ажилтнуудын дунд 3, байгууллагыг иргэд, олон нийтэд сурталчлах 2, нийт 20 төрлийн спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахаар төлөвлөн шаардлагатай 166.3 сая төгрөгийн тооцоо, судалгааг гаргасан бөгөөд түүхт ойн спортын уралдаан, тэмцээний 815 ширхэг медалийг 15.485.000 төгрөгөөр захиалж, энэ оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авсан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын удаа дараагийн тогтоол, шийдвэрийн хүрээнд олон нийтийг хамарсан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахыг зогсоосон тул хэрэгжилт, бэлтгэл ажлын явц удааширч байна.

Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойд зориулсан “Нөхөрсөг-уулзалт” тэмцээн буудлага, биллъярд, гар бөмбөг гэсэн 3 төрлөөр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдах бүрэлдэхүүний дунд энэ оны 03 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд тусгайлсан чиг үүрэгтэй 14 байгууллагын удирдах бүрэлдэхүүний дунд болсон тэмцээнд Цагдаагийн ерөнхий газрын баг 9 оноогоор тэргүүн байрт шалгарсан.

Тус спорт хорооны дасгалжуулагч, цагдаагийн ахмад, МУГТ М.Уранцэцэг Олон Улсын жүдо бөхийн холбоо /IJF/-ны цуврал “Доха Мастерс 2021”, “Ташкентын гранд слам”, “Тбилисийн гранд слам” болон Унгар Улсын Будапешт хотод зохион байгуулагдсан жүдо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс нийт 2 алт, 2 хүрэл медаль, цагдаагийн ахлах ахлагч, МУГТ Э.Бэхбаяр Болгар улсын Софи хотноо зохион байгуулагдсан “СОФИ-2021” тэмцээнээс мөнгө, цагдаагийн дэд ахлагч, ОУХМ Т.Тулга Италийн нийслэл Ром хотод зохион байгуулагдсан Дэлхийн чансааны оноо олгох Маттео Пелликонегийн нэрэмжит “А” зэрэглэлийн Олон улсын тэмцээнд мөнгөн медаль тус тус хүртэж, 3 алба хаагч “Токио-2020” зуны олимпын XXXII наадамд оролцох эрх авсан.

### **Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар**

Гүйцэтгэлээр 15.5 сая төгрөгөөр спортын арга хэмжээнүүдэд оролцсон тамирчдын медаль, цагдаагийн байгууллагын сүр хүч, бэлгэ тэмдэг болох “Цагаан шонхор” 3D видео анимешн хийлгэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тууж, роман, зохиолын уралдаан зохион байгуулж, шалгаруулах уралдааныг зарлан дүгнэж, Сүлд чуулгын алба хаагчдын тоглолтын хувцас, хөгжмийн зэмсэг худалдан авах, Виртуал музей байгуулах ажлыг тендер зарлан шалгаруулж гэрээ байгуулсан бөгөөд тэмдэг, логоны загвар хийлгэхэд 6.3, “Сүлд чуулга”-ын алба хаагчдын хувцас, хөгжмийн хэрэгсэлд 89,2, гар зургийн уралдааны зардалд 14.5, бусад зардалд 7.0 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагч, ажилтны гэнэтийн ослын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Ард даатгал” ХХК-тай 122.9, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Номин даатгал” ХХК-тай 175.0, үл хөдлөх хөрөнгийн даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчээр “Номин даатгал” ХХК-тай 61.2 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны төсвийн урсгал санхүүжилтийн зардалд 253.5 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 8.3 тэрбум төгрөг, нийт 261.9 тэрбум төгрөгийг баталсан ба үүний 168.2 тэрбум төгрөг буюу 64.2 хувь нь цалин, ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалын зардал, 8,3 тэрбум төгрөг буюу 3.2 хувь нь хөрөнгө оруулалтын зардал, 67.2 тэрбум төгрөг буюу 25.7 хувь нь урсгал зардал, 18,1 тэрбум төгрөг буюу 6.9 хувь нь тэтгэмжийн зардал байна.

Төсвийн зарлагын санхүүжилтийн хуваарийн дагуу эхний 5 сард урсгал зардалд нийт 111.043,4 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 92.281.1 сая төгрөг зарцуулж 18.762,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 83.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгосон алба хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмжийг 68 алба хаагчдад 3.011.0 сая төгрөг, Цагдаагийн албаны тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.2 дахь хэсэгт “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшил”-ыг 40 алба хаагчид 672.0 сая төгрөг, ажил үүргээ гүйцэтгэж байгаад нас барсан 1 алба хаагчийн ар гэрт 120 сарын тэтгэмж 114.2 сая төгрөг, өвчний улмаас нас барсан 4 алба хаагчийн ар гэрт 36 сарын тэтгэмж 146.4 сая төгрөгийн тус тус олгосон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/212 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 8.4 тэрбум, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 18.4 тэрбум төгрөг тус тус тусгагдсан бөгөөд тухайн төлөвлөгөөний хүрээнд давхардсан тоогоор нийт 32 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, 30 үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/321 дүгээр тушаалаар цагдаагийн алба хаагчдын 2021 оны хэрэгцээт дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг бэлтгэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий “Үнэлгээний хороо”-г 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, төлөвлөгдсөн 40 багц /39 нэр төрөл/-ын 7.763.050.000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй “ЦЕГ/202112016” дугаартай тендер шалгаруулалтыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зарлаж, шалгарсан дотоодын 20 аж ахуйн, нэгж байгууллагаар нийт 7.460.614.400.00 төгрөгөөр бэлтгүүлэхээр шийдвэрлэж, 302.435.600 төгрөгийн хэмнэлтийг гаргасан.

Хангалт, үйлчилгээний төв цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын албанаас халагдаж, чөлөөлөгдсөн 605 алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас, хэрэглэлийн 300.719.148 төгрөгийн төлбөр тооцооны үлдэгдэлтэй байсан бөгөөд энэ оны хагас жилийн байдлаар албанаас халагдаж, чөлөөлөгдсөн 195 алба хаагчийн 142.163.928 төгрөгийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас хэрэглэлийн төлбөрийн нэхэмжлэлийг гаргаж харьяа анги, байгууллагуудад хүргүүлж, 348 алба хаагчийн хувцасны төлбөрт 154.615.438 төгрөгийн төлбөр барагдаж, нийт 549 алба хаагчийн 286.831.139,85 төгрөгийн төлбөр тооцооны үлдэгдэлтэй байна.

“Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилал эхний хагас жилийн хугацаанд амралтад насанд хүрсэн 179 хүн, 41 хүүхэд, сувилалд насанд хүрсэн 367 хүн, 55 хүүхэд, нийт насанд хүрсэн 546 хүн, 96 хүүхэд хүлээн авч, 28 нэр төрлийн хоол, 14 нэр төрлийн хачир, 10 нэр төрлийн ундаа бэлтгэн үйлчилсэн.

Хамгаалалтын хувцас 47330 ширхэг, халуун хэмжигч 60 ширхэг, нэг удаагийн улавч 44550 ширхэг, нэг удаагийн амны хаалт 1502882 ширхэг, нэг удаагийн малгай 55250 ширхэг, нэг удаагийн бээлий 103717 ширхэг, нүдний шил 17723 ширхэг, нүүрний хаалт 9050, нэг удаагийн N95 амны хаалт 97126 ширхэг, даавуун амны хаалт 48150 ширхэг, ариутгалын бодис 5643 ширхэг, гар ариутгагч 17986 ширхэг, ариутгалын спирт 6810л, автомакс 332 ширхгийг тус тус худалдан авсан.

Автомакс 332 ширхэг, ариутгалын спирт 6561литр, Хамгаалалтын хувцас 47280 ширхэг, Гар ариутгагч 17922 ширхэг, 1502882 ширхэг, нүдний шил 17723 ширхэг, нэг удаагийн N95 амны хаалт 96920 ширхэг, нэг удаагийн бээлий 102717 ширхэг, нэг удаагийн малгай 55250 ширхэг, нэг удаагийн улавч 44550 ширхэг, даавуун амны хаалт 47382 ширхэг, Ариутгалын бодис 5642 ширхгийг тус тус олгосон.

### **Дөрөв. Дүгнэлт**

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаа.

-Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан бүтээн байгуулалтын олон төрлийн ажил, арга

хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, бүх шатны удирдах албан тушаалтны, ахлагч бүрэлдэхүүний зөвлөгөөнийг цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

-Улсын хэмжээнд нийт 10595 гэмт хэрэг бүртгэгдсэний 6715 буюу 63.4 хувь нь нийслэлд, 3868 буюу 36.5 хувь нь орон нутагт, 12 буюу 0.1 хувь нь бусад газар /хилийн чанадад/ бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 3348 буюу 24.0, нийслэлийн хэмжээнд 2349 буюу 25.9, орон нутагт 998 буюу 20.5, бусад газар /хилийн чанадад/-т 1 буюу 7.7 хувиар тус тус буурсан.

Гэмт хэргийн илрүүлэлт 44.2, нийслэлд 43.4, орон нутагт 46.4 хувь байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 0.2, нийслэл хотод 2.0 нэгжээр тус тус өссөн.

- Монгол төрийн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үеийн хэв журмын хамгаалалт, зохицуулалтыг амжилттай зохион байгуулсны зэрэгцээ дэлхийн нийтэд тархаад буй коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас иргэд, олон нийтийг урьдчилан сэргийлэх хамгаалалтад өнгөрсөн оны 11 сараас өнөөдрийг хүртэл ачаалал ихтэй ажиллаж байна.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР